



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 1/02

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Байгууллагын дэргэдэх ёс зүйн
дэд хороог шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 67 дугаар зүйлийн 67.5, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захирагчийн ажлын албан хаагчдын үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх үүрэг бүхий байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: А.Нарантуяа - Санхүү албаны дарга

Гишүүд: Б.Энхсаруул - Нийгмийн бодлогын мэргэжилтэн
У.Номинзаяа - Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Байгууллагын албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг сурталчилан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт болон нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах, дүгнэлт гаргах зэрэг ажлуудыг хариуцлагатай хийж ёс зүйн дэд хорооны тайланг хагас болон бүтэн жилээр тайлагнан ажиллахыг ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОТГОНБАЯР